



**“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 04 дүгээр сарын
25- ны өдөр

Дугаар 01.18

Улаанбаатар хот

Хурлын ирцийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа.

ХЭХуралд 631433 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид санал авах хуудсаар, 2257021 саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр болон итгэмжлэлээр хуралд хүрэлцэн ирснээр нийт 2888454 санал эрхтэй хувьцаа эзэмшигчид буюу саналын эрхийн 83.0%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ээлжит хуралд оролцсоноор Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 69 дүгээр зүйлийн 69.1 дугаар заалтад заасан хүчин төгөлдөр ирцид хүрснийг хурлын дарга болон хуралд оролцогчдод мэдээлэв.

Хурлыг ТУЗ-өөс томилсноор Д.Мөнхбат даргалав. Ирцийг сонгосны дараагаар хуралд даргалагч хурлын дэгийг хэлэлцэж батлуулав. Үүнд:

1. “Ариг гал” ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайлан 15 мин (илтгэгч нь АГ ХК-ийн ГЗ Х.Хания)
2. “Ариг гал” ХК-ийн 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийн хэлэлцүүлэх 15 мин (илтгэгч нь ТУЗ-ийн аудитын хорооны гишүүн Б.Аюуш)
3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох. Танилцуулгыг 20 мин (ТУЗ-ийн н.б Л.Нямжав)
- 4 Ногдол ашиг хуваарилах талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцүүлэх
Танилцуулга 10 мин (ТУЗ-ийн н.б Л.Нямжав)
5. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэх Танилцуулга 20 мин (ТУЗ-ийн н.б Л.Нямжав)
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл
Хүн тус бүрт 3 мин (хурлын дарга Д.Мөнхбат)
7. Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, саналын дүнг гаргах, ХЭХ-д саналын дүнг танилцуулах.цаг тогтоохгүй (тооллогын комисс Б.Цолмон) гэсэн дэгийг хуралд оролцогчид ил саналын 100%-ийн дүнгээр батлав.

Хурлыг 2.30 цагт багтаан явуулахаар 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 17.45 цагаас эхлүүлээ.

Д.Мөнхбат- ТУЗ-өөс томилсон тооллогын комиссын дарга Д.Даваасүрэн өвчний учир хуралд ирж чадахгүй болсон тул тооллогын комиссын даргаар Б.Цолмонг сонгох саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцогчдын ил санал хураалтын 100%-ийн саналаар Б.Цолмонг тооллогын комиссын даргаар сонголоо. Үүний дараа хурал даргалагч хурлын хэлэлцэх асуудалдаа орлоо.

Хэлэлцсэн нь:

1. Х.Хания компанийн 2017 оны ажлын тайланг тавьлаа. Үүнд.

Тус компанийн гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө 2017 оныхоо үйл ажиллагааг тайлагнаж, 2018 оныхоо зорилтыг тодорхойлох гэж байна.

Компанийн гүйцэтгэх удирдлага өнгөрсөн онд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн өмнө дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө компанийн дүрэм, ТУЗ-өөс олгосон эрхийг хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэж ажиллаа.

Нэг. Борлуулалт орлогын талаар:

Манай компани түрээсийн орлого, ноогдол ашиг гэсэн хоёр үндсэн эх үүсвэрээс орлогоо бүрдүүлдэг. Өнгөрсөн онд хуралдсан хурлаас 2017 онд 1040,0 сая төгрөгийн орлоготой байхаар төлөвлөсөн. 1,987,5 сая.төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөсөнөөс 191%-ийн биелэлттэй буюу өнгөрсөн онтой харьцуулахад 20%-иар орлого өссөн.

Бусдаас авсан ногдол ашгийн орлого 1,6 тэрбум төгрөг болсон. Энэ орлого нь нүүрсний зах зээлийн үнэ, нийлүүлэлт өссөн төдийгүй улс орны хэмжээнд энэ салбарын үйл ажиллагаа гаанд эерэг нөлөөлөл бий болгож Таван толгой ХК-иас дээрхи ногдол ашгийг хуваарилсан юм.

Хоёр: Санхүүгийн байдлын талаар:

Компани нь тайлант жилийн орлогыг 1,7 тэрбум.төг-т хүргэж төлөвлөгөөг 60,2%-иар, ашгийн даалгаврыг 11,4%-иар биелүүлж татварын дараах ашгийн 50%-иар буюу 74,2 сая.төг-ийг ноогдол ашгийг хуваарилах боломжтой байна.

2017 оны тайлан балансаар үйл ажиллагааны зардал 983,5 сая төгрөгөөр буюу 50% өссөн. Үүний гол шалтгаан нь зээлийн хүүгийн зардал 757,6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 7,8 сая төгрөгөөр мөн ашиглалтын зардал 130,4 сая төгрөгөөр тус тус өссөн, харин бусад зардал 51,9 сая төгрөгөөр, томилолт, шуудан холбоо, шатахууны зардал 16,3 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн бөгөөд дээрх зардлуудын өөрчлөлтийн зөрүүгээр төсөвлөснөөс 983,5 сая төгрөгөөр зардал өссөн юм. Санхүүгийн тайлан балансаас харахад өнгөрсөн 2017 онд төлөвлөсөн зардлаас 50% хувиар өссөн харагдаж байна.

“Ариг гал” ХК нь улсын төсөвт НӨАТ, Үл хөдлөх хөрөнгийн татвар ХАОТ, НДШ зэрэг тавар шимтгэлээр нийт 232,5 сая төгрөгийг төвлөрүүлээ.

Гурав: Өнгөрсөн оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт нь дараах биелэлттэй гарлаа. Үүнд:

1.Төв аймгийн Баян суманд шохойн чулуун ордод хөрс хуулалтын ажлыг явуулсан, энэ оноос олборлолт хийхэд бэлэн болсон. Энэ оноос шохойн чулууны олборлолт хийж борлуулах төлөвлөгөөтэй байна.

2. Компанийн бололцоотой талбайг суллаж, түрээсийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр 400 ам.м талбай бүхий байрыг чөлөөлж хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар байрыг засварлаж ашиглалтад хүлээлгэж өгөөд байна.

3.Түрээсийн болон инженерийн байгууламжийн үйлчилгээнээс олох орлогыг 15,2%-иар нэмэгдүүллээ.

4.Орлогоо өсгөх замаар өмнөх оноос төлөгдөөгүй хуримтлагдсан зээлийн хүүгээс 1,0 тэрбум төгрөгийн төлөлтийг хийж, санхүүгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэхэд тодорхой ахиц гарсан.

Дөрөв. Компанийн удирдлага зохион байгуулалтын талаар

“Ариг Гал” ХК-ийн удирдлагын бүтэц нь ХЭХ, ТУЗ, ТУЗ-ийн даргын АА гэсэн бүтцээр ажиллаж байна. ТУЗ-ийн даргын АА нь ТУЗ-д туслах чиг үүрэгтэй бөгөөд АГ ХК нь группийн толгой компани болно. АГ ХК нь дороо 3 охин компани /МПП ХХК, БСТ ХХК, КХ ХХК/ тай. КХ ХХК-нь дороо 7 охин /ХШ ХХК, АО ХХК, ММ ХХК, ЭО ХХК, ТШ ХХК, ГМ ХХК, Эвсэг ХХК/ компанитай, мөн хувьцаагаар хөрөнгө оруулалттай МН ХК, ДН ХК-иуд харъяалагдан үйл ажиллагааг явуулж байна.

ТУЗ-ийн хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн дарга нь АА-аараа дамжуулж эдгээр бүх компаниудыг нэгдсэн менежментийн бодлого удирдлагаар хангаж, группийн харъяа компаниудын ажлыг сар бүр шалгуур үзүүлэлтээр дүгнэн шалгаруулж, ажилтнуудын хариуцлага ажлын

үр дүнгийн төлөө санаачлага гаргаж зүтгэж ажиллах идэвх санаачилгыг идэвхжүүлж ажилласнаар группийн харъяа компаниудын хэмжээгээр 2017 онд 22,2 тэрбум төгрөгийн орлоготой, 142,4 сая төгрөгийн ашигтай ажиллаа.

Манай компаниудын бүтээн бий болгосон нэмүү өртгөөс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад албан татвараар улсын төсөвт 3,3 тэрбум төгрөгийн төлөвлөрүүлсэн нь өмнөх оноос 57,5 %-иар өссөн байна. Ийнхүү манай хамт олон нийгмийн томоохон хариуцлагатай компани болж, улс орныхоо эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмэр оруулж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж байгаа нь манай ажилчид, инженер, менежер рүүдийн ажлын үр дүн, хувьцаа эзэмшигчдийн дэмжлэгийн үр дүн гэж дүгнэж байгаа тул та бүхэнд талархалаа илэрхийлье

Тав. Хувьцаа эзэмшигчдийн тухай танилцуулах нь

Өнөөдөр тус компанийн хувьцааг өнөөдөр 7424 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Хувьцааны 52.4%-ийг нэгдмэл сонирхолтой этгээд болох Эрч нийгэмлэгээр 19.99%, Ээрүүл нийгэмлэгээр 19.99-ийг эзэмшиж байгаа бөгөөд эдгээр нийгэмлэгүүдийн гишүүд нь АГ ХК болон КХ ХХК, түүний охин компаниудад ажилладаг ажилтнууд байна. ТУЗ-ийн дарга хувьцааны 12.4%-ийг эзэмшдэг. Эдгээр нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь 1995-онд компанид болон МХБ,СЗХ-нд нэгдмэл сонирхолтой болох тухайгаа хууль журмын дагуу мэдэгдэж бүртгүүлсэн байгаа.

Компани өөрийн хувьцааны 3.2%-ийг халаасласан байна. Бусад 44.4%-ийн хувьцаа нь 7420 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа болно.

Зургаа. Ногдол ашгийн хуваарилалтын тухай.

Тус компани 2015 онд нийт ашгийн 60%-иар нэгж хувьцаанд 33.00 төг буюу нийт 114.8 сая.төг-ийг, 2016 онд нийт ашгийн 50%-иар, нэгж хувьцаанд 17.82 төгрөг буюу нийт 62.0 сая.төг-ийг, 2017 онд нийт ашгийн 50%-иар нэгж хувьцаанд 21.33 төгрөг буюу нийт 74.2 сая.төг-ийг нийтдээ 251.0 сая.төг-ийг хуваарилаад байгаа бөгөөд 2018 оны 9 сараас хэтрүүлэхгүйгээр нийтад зарлан тараахаар бэлтгэж байна. Улс орны эдийн засаг хүндрэлтэй, санхүүгийн нөөц бололцоо хязгаарлагдмал байгаа өнөөгийн нөхцөлд шинээр 211 хүнийг ажлын байраар хангаж 4 компанид 20 ажилтаныг дэвшүүлэн ажиллуулан, ажиллагсдынхаа цалин хөлсийг хугацаанд нь олгож байгаагийн дээр компаниудын дүнгээр ажилтнуудын ажлын үр дүнгээр шагнал урамшуулах, тэтгэмж, дэмжлэгийн арга хэмжээнд 100.0 гаруй сая.төг- ийг зарцууллаа.

Долоо. Цаашид хийх ажил:

Компанийн 2018 оны үйл ажиллагааг дараахи үндсэн ажилд чиглүүлэхээр төлөвлөж байна.

1.Төв аймгийн Баян сумын нутаг дахь Шохойн ордны хөрс хуулалт,тэсэлгээ,олборлолтын үйл ажиллагааг явуулж борлуулалт хийж ашиг орлогыг нэмэгдүүлэх.

2.Компанийн сул чөлөөтэй байгаа газрыг түрээслүүлж,орлого нэмэгдүүлэх.

3.Үйлдвэрлэлийн компаниудын үйл ажиллагаа,үр ашгийг дээшлүүлэхэд

анхаарч үл хөдлөх хөрөнгө,газар эзэмших эрхээ барьцаалж эргэлтийн хөрөнгийн зээл авахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажлаа төлөвлөснөө танилцууллаа.

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа,санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг аудитын хорооны гишүүн Б.Аюуш хуралд орууллаа.

Нэг. Санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгө өр төлбөрийн өнөөгийн байдлаар талаар

Компанийн нийт хөрөнгө 62.9 тэрбум төгрөгт хүрч, тайлант жилийн хугацаанд 9.2 тэрбум төгрөгөөр буюу өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад 0.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ бууралтын 1.3 тэрбум төгрөг нь авлагын бууралттай холбоотой учраас хэвийн үзүүлэлт гэж үзлээ. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд дансны өглөгийн үлдэгдэл 176,6 сая төгрөгөөр, татварын болон НДШ-ийн өр төлбөрийг тус бүр 61,1 сая болон 6,1 сая төгрөгөөр бууруулсан байна. Группийн толгой компанийн үүрэг гүйцэтгэн охин компаниудын үйл ажиллагааг зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрээр хангах үйл ажиллагаа эрхэлж байгаа учраас группийн доторх хоорондын тооцооны өглөг авлага,

дийлэнх хувийг эзэлж байгаа боловч, авлагыг насжилтаар нь ангилан найдваргүй болсон хэсгийг данснаас хасах, өр төлбөрийн зарим хэсгийг холбогдох компанийн данс бүртгэлд шилжүүлэн бүртгэх зэргээр зохицуулалт хийх шаардлагатай байдал харагдаж байна. Гэхдээ авлагын үлдэгдэл 35,8 тэрбум төгрөг байхад өрийн үлдэгдэл 45,5 тэрбум төгрөг байгаа нь даруй 9.7 тэрбум төгрөгийн зөрүүтэй байгаагийн шалтгааныг гүйцэтгэх удирдлагын зүгээс тайланд тодорхой тусган дүн шинжилгээ хийж харуулаагүй байна. Жил дараалан анхааруулсаар ирсэн боловч нийт хөрөнгийн 8,9 хувийг эзэлж буй бусад эргэлтийн бус хөрөнгийн талаарх тайлбараа санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаагүй хэвээр байна.

Тайлангийн хугацаанд урт хугацаат зээлийн үлдэгдлийг 1,05 тэрбум төгрөгөөр бууруулсан нь компанийн санхүүгийн байдалд мэдэгдэхүйц нааштай өөрчлөлт гарахад хүргэсэн байна.

Хоёр. Орлого

Ариг гал ХК нь үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг охин компаниудад шилжүүлж, үйл ажиллагааг нь зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг хангах зэргээр холдингийн толгой компанийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байгаа учраас нь орлогын эх үүсвэр нь:

А. Ногдол ашиг	1670,3 сая төгрөг
Б. Түрээсийн орлого	303,6 сая төгрөг
В. Хүүгийн орлого гэсэн хэлбэртэй байна.	14,6 сая төгрөг байна.

Түрээсийн орлого 303,6 сая төгрөг болж өнгөрсөн оныхоос 53,1 сая төгрөгөөр, ногдол ашгийн орлого өнгөрсөн оныхоос 1670,3 сая төгрөгөөр тус тус өсч, хүүгийн орлого 300,1 сая төгрөгөөр буурсан байна. Эндээс үзэхэд охин компанид олгосон зээлийн хэмжээ 1,05 тэрбум төгрөгөөр буурсан нь хэдий ч төлсөн зээлийн хүүгийн хэмжээ буураагүй шалтгааныг гүйцэтгэх удирдлагын хэлэлцүүлэг дүн шинжилгээ хийж тайлбарлаагүй байна. Түрээсийн орлогын хувьд 53,1 сая төгрөгийн өсөлт байгаа нь компанийн бололцоотой талбайг суллаж, түрээслэн орлогыг нэмэгдүү лэхэд анхааран, 400м² талбай бүхий байрыг чөлөөж, хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар засварлаж ашиглалтад өгсөн байна. Инженерийн байгууламжийн үйлчилгээээс олох орлого 15,2 хувиар нэмэгдсэн зэрэг нь нөлөөлжээ.

3. Зардал

Тайлант онд нийт зардал өнгөрсөн оныхоос өсч, 1497,1 сая төгрөгт хүрсний шалтгаан нь зээлийн хүүгийн зардал 757,6 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна. Өөрөө аж ахуйн ямар нэг үйл ажиллагаа эрхлээгүй зээл авах, охин компанид зээлийн болон бусад хэлбэрээр санхүүжилт хийх ажиллагаа эрхэлж байгаагийн хувьд хүүгийн зардалын хэмжээ ингэж өссөн нь хэвийн бус үзэгдэл гэдгийг анхааралдаа авч, шалтгаан, цаашид авах арга хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хуралд болон ТУЗ-д танилцуулах шаардлагатай байна. Бусад зардлын хувьд хэвийн хэмжээнд байна.

4. Санхүү эдийн засгийн ерөнхий төлөв

Санхүү эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оны түвшинд байна. Энэ нь Тавантолгой ХК-аас авсан ногдол ашгийн 1,6 тэрбум болсонтой холбоотой байна. Толгой компанийн хувьд хэрэгжүүлсэн санхүүгийн үйл ажиллагаанд банкны зээлийн хүүгийн өндөр түвшин нөлөөлсөөр байна. Цаашид толгой компанийн хувьд хэрэгжүүлж буй арга хэмжээг хэвийн түвшинд хүргэх талаар нухацтай хэлэлцэж арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай болоод байна. Удирдлагын тайланд өглөг авлагын тооцоо түүний өөрчлөлт, ашгийн түвшин, ногдол ашиг олох боломж зэргийг охин компани тус бүрээр харуулж, дүгнэлттэй тайлагнадаг байхыг анхааруулж байна.

Мөн түүнчлэн өнгөрсөн жилүүдэд толгой компанийн хэлбэртэй ажиллах болсны улмаас бүтэц зохион байгуулалтад орсон өөрчлөлт үүнтэй холбоотой хэрэгжүүлж байгаа удирдлага, хяналтын арга хэмжээ, дүрэм журам тогтоосон байдал зэргийг тайлагнаж байхыг анхааруулсан боловч энэ жил мөн л энэ асуудлыг тусгаагүй хэвээр байна. Компанийн үйл ажиллагаанд гарсан бас нэг ахицтай зүйл нь Төв аймгийн Баян суманд шохойн чулууны ордод хөрс хуулалтын ажлыг дуусгаж ашиглахад бэлэн болгосон байна.

Иймэрхүү арга хэмжээ авч хэрэгжүүлэх замаар манай орны санхүүгийн зах зээлийн гажуудал компанийн үйл ажиллагаанд үзүүлж буй сөрөг нөлөөллийг зөөлрүүлэхэд дотоод боломжоо ашиглах чиглэлд гарч буй томоохон алхам гэж үзэж байна.

Дүгнэлт

Компанийн болон компани нэгдлийн хэмжээнд үйл ажиллагаа хэвийн явж ирсэн гэж үзэж байна.

Нэгдлийн хэмжээнд эдийн засгийн хүндрэлтэй энэ үед 211 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн, цалингийн түвшинг бууруулалгүй хадгалж ирсэн, борлуулалт болон ашгийн түвшинг хадгалж ирсэн зэрэгт үндэслэн дээрх дүгнэлтийг өгч байгаа болно.

Гэвч өнгөрсөн жилийн тайлангаар өгсөн зарим үүрэг биелэгдээгүй байгааг болон охин компани тус бүрээр гүйцэтгэлийг тайландаа тусгадаг байхыг дахин анхааруулж байна.

Мөн түүнчлэн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасан асуудлыг бүрэн тусгасан тайланг толилуулж байх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг ТУЗ-өөс ХЭХ-д орууллаа.

3. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулгыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа.

4. 2017 оны НА хуваарилах тухай, ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа. 2017 онд цэвэр ашгийн 50%-иар НА хуваарилах шийдвэрийг ТУЗ гаргасан. Энэ нь нэгж хувьцаанд 21.33₮ буюу нийт 74.2 сая.төг (далан дөрвөн сая хоёр зуун мянган) хуваарилах юм байна. Тус компани 2015 онд нийт ашгийн 60%-иар нэгж хувьцаанд 33.00 төг буюу нийт 114.8 сая.төг-ийг, 2016 онд нийт ашгийн 50%-иар , нэгж хувьцаанд 17.82 төгрөг буюу нийт 62.0 сая.төг-ийг хуваарилаад олгоогүй байсныг 2017 оныхтой зэрэг зарлаж нийт 251.0 сая.төг-ийг 2018 оны 9 сараас хэтрүүлэхгүйгээр нийтад зарлан тараана гэдгээ мэдэгдлээ.

5. Ариг гал ХК-ийн ХЭХ,ТУЗ-ийн зардлын төсвийн 2017 оны гүйцэтгэл, 2018 оны зардлын төсөвийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Нямжав танилцууллаа. 2017 оны гүйцэтгэлээр зардлыг 29.5%-иар хэмнэлттэй зарцуулсан нь ТУЗ-ийн гишүүдийн сургалтын зардал, албан томилолтын зардал хэмнэгдсэнээр хэмнэлттэй гарсан харин 2018 оны төсөвийг өмнөх онд төлөвлөсөн хэмжээгээр буюу 52298.мян.төг (тавин хоёр сая хоёр зуун ерэн найман мянган)-өөр оруулж байгааг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал дууссаны дараа санал шүүмжлэлд орлоо.

Д.Мөнхбат: Хурлаар хэлэлцүүлэх асуудал дууслаа Санал шүүмжлэлдээ оръё.

Хувьцаа эзэмшигч Даваа-Очир : Хувьцаа халааслалт 3,2% эзэлж байна гэж байна? Энэ ямар шугамаар халааслан , ямар ажил хийгдсэн бэ?

Л.Нямжав: Халаасны хувьцаа 3,2% байгаа. Үүний 2.2%-ийг анх 1995 онд хоёр дахь зах зээлээс арилжаагаар худалдан авсан. Тухайлбал компаний дүрмийн санг нэмж гаргасан хувьцааг хаалттай захиалгын үндсэн дээр арилжаалах төслийг санхүүгийн зохицуулах хороонд оруулсан. Хороо уг төслийг дэмжсэн шийдвэр гаргахдаа хувьцааг нийтэд арилжаалах хувьцаа гэсэн шийдвэр гаргаж өгсөн. Энэ үед арилжаагаар авсан хувьцаа байгаа юмаа. Харин 1% нь 2010 оноос хойш өөрийн хувьцааг ТУЗ-ийн шийдвэр гаргуулж халаасласан хувьцаа байгаа.

Хувьцаа эзэмшигч Ганбаатар : Өнгөрсөн онд охин компаниудаас орлого олсон уу? Кашмер Холдинг ХХК-ний орлого бол өндөр байгаа биздээ.

Ц.Цэнгэлбаяр: Сайн байцгаана уу? Ариг Гал ХК-ийн ерөнхий нябо байна. Өнгөрсөн онуудад ногдол ашиг аваагүй байгаа. Ноолуурын үйлдвэр нь хүнд нилээн махчилсан олон нэмүү өртөг бүтээгддэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул одоогоор ногдол ашиг авах хэмжээнд ашгийн түвшин хүрээгүй байна. Одоогоор хөрөхгө оруулалт 8 жил үргэлжилж байна. Кашмер Холдинг ХХК-ийн борлуулалт өссөн байгаа. Түүнтэй холбогдуулан маш их хөрөнгө оруулалт болон шинэ технологи гаргах үйл ажиллагаа явагдаж байгаа тул ногдол ашиг авах хэмжээнд хүрээгүй байгаа. Улсын төсөвт 6,3 тэрбум төгрөгний татвар, нийгмийн даатгал төлж 800 орчим ажилтануудыг ажлын байраар хангаж ажиллаж байгаа. Өнөөдөр уул уурхай шиг их ашиг олох хэмжээнд ажиллахгүй байгаа. Үйлдвэр маань 1981 онд байгуулагдсан хонины ноосон утас ээрдэг үйлдвэр байсан, утас хэрэглэдэг үйлдвэрүүд нь ажиллахаа больсон зарим нь зах зээлгүй болсон зах зээл нь багассанаас дотооддоо ээрсэн утасны хэрэгцээг хангадаг болсноос утасны үйлдвэр бүрэн зогссон. Иймээс сүүлийн 20-иод жил шинэ зах зээлд нэвтрэх, бүтээгдэхүүний чанар, өнгө дизайнаа шинэчлэхийн тулд байнга шинэчлэлт хийж гадаад зах зээлд гарахын тулд хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсээр байна. Засгийн газраас хангалттай сайн дэмжлэг, зээлийн хүүгийн хөнгөлөлтийн бодлого дэмжлэг хангалттай сайн ирэхгүй байна. Иймээс бид хадагаламж зээлийн хоршоо банк санхүүгийн байгууллагаас өндөр хүүтэй зээл

авч ажиллаж байна. Нилээд их хөрөнгө оруулалтыг бид өөрсдийн хөрөнгө оруулалтаар хийж байна.

Хувьцаа эзэмшигч Эрдэнэжаргал байна: Охин компаниудын тайланг толгой компани дээр нэгдсэн тайлан дээр гаргах боломж байна уу? Гаргаснаар ямар сул талууд байна вэ? Хэрвээ нэгдсэн тайланг гаргавал хувьцаа эзэмшигчид ашигтай хувьцааны ханш өндөр болох боломж байгаа. Таван толгойгоос ногдол ашиг жил бүр авч байгаа. Хэдэн ширхэг хувьцаа буюу компаний хэдэн хувийг эзэмшдэг вэ?

Ц.Цэнгэлбаяр: Бид нар албан ёсны нэгдсэн тайланг гаргаагүй. Компаний хэмжээнд 22 тэрбум төгрөгний борлуулалтын орлоготой үүнээс ашиг 429 сая төг байгаа. Үүнээс “Ариг гал” ХК 145 сая төгрөг, “Кашмер Холдинг” ХХК 142 сая төгрөг, бусад охин компаниуд 67 сая төгрөг тус тус байгаа. Эдгээр нь дараагийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрж, хүний нөөцийн асуудал буюу хүн хүч сургах ажилд зарцуулагдаж байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байгаа. Манай салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг сургууль, коллежүүд цөөхөн байна. Иймд хүн хүч сургахад зардал их гарч байгаа.

Л.Нямжав: Асуултын сүүлийн хэсэгт хариу өгье. Манай компани Таван толгой ХК-ийн хувьцааны 4%-ийг эзэмшиж байгаа. Уг хувьцааны ногдол ашгаас Та бүхэнд НА хүртээж байгаа.

Хувьцаа эзэмшигч/БиДиСек ХХК/ Билгүүн: Банкнаас зээл авсан уу? Шохойн ордын үйл ажиллагаа хэр явагдаж байгаа вэ?

Ц.Цэнгэлбаяр: Банкны зээл 2011 онд 6.0 тэрбум төгрөгийг Чингэс хаан банкнаас жилийн 20%-ийн хүүтэй авсан. Өнөөдрийн байдлаар 1,2 тэрбум төгрөгний үлдэлтэй байгаа. Энэ ондоо төлж дуусах төлөвлөгөөтэй байгаа.

Шохойн орд хайгуул хийх үйл ажиллагааг явуулж 4 жил болсон. Одоо хөрсөө хуулсан, олборлолтын үйл ажиллагаа дөнгөж эхэлж байна. Борлуулалтын үйл ажиллагаа удахгүй хийнэ. Энэ жилдээ урьдчилсан тооцоогоор 10 тн борлуулж чадвал тодорхой ашиг олно. Шохойн орд дээр ажил эхэлсэн байгаа энэ жилээс ашиг олж эхэлнэ гэж ойлгож болно.

Энхбаяр: 6 жилийн өмнө ирж байсан. Жил ирэх тусам өнгө засч хийсэн зүйлүүд тань өргөжиж баярлуштай зүйлүүд их болсон байна. Амжилт хүсье. Илүү сайн ажиллаарай.

Г.Туул: Хувьцаа эзэмшигчиддээ харамгүй өгөөд үз. Өгнө гэдэг зарчим маш гоё. Бүтээгдэхүүнүүд маш гоё байна. Гэтэл маш үнэтэй тул бид авч чаддаггүй. Тиймээс дундаж үнэтэй бүтээгдэхүүн гаргаж баймаар байна. Сайхан бүтээгдэхүүн хийж байгаад баярлалаа. Эх оронч үзлээр хийж байгаад баярлалаа баяр хүргэе.

Д.Мөнхбат- өөр санал шүүмжлэл хэлэх хувьцаа эзэмшигч байна уу. Байхгүй бол санал шүүмжлэлээ таслах уу? ХЭ-чид гар өргөж санал шүүмжлэлийг хаав.

Үүний дараа тооллогын комисс саналын хуудасыг хувьцаа эзэмшигчдээс хурааж санал тоолох ажилдаа орлоо.

Тооллогын комисс саналын дүнг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулсны дараа Хурлын дарга хурлаас гаргах шийдвэрээр тогтооллын төслүүдийг уншиж танилцуулав. Тогтоолуудыг хувьцаа эзэмшигчдийн ил саналын 100%-ийн дүнгээр баталлаа.

ХУРЛААС ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Хуралд орсон хувьцаа эзэмшигчдийн 2888347 саналаар буюу 100%-ийн саналаар Гүйцэтгэх захирлын Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайланг, 2888347 санал буюу 100%-ийн санлаар ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх удирдлагын Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлахаар шийдвэрлэв.

2. ХЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив

1. 2889183 санал буюу 16.8%-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
2. 2888301 санал буюу 16.7%-ийн саналаар Д.Гиваапилийг,
3. 2889299 санал буюу 16.7%-ийн саналаар Д.Мөнхбатыг,
4. 2889314 санал буюу 16.7%-ийн саналаар С.Алимааг,
5. 2889297 санал буюу 16.7%-ийн саналаар Х.Ханияг,

6. 2889298 санал буюу 16.7%-ийн саналаар Б.Ёндонжамцыг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр сонгов.

7. 2888726 санал буюу 33.34%-ийн саналаар Б.Болдыг,

8. 2888289 санал буюу 33.33%-ийн саналаар Б.Аюушийг,

9. 2888279 санал буюу 33.33%-ийн саналаар Э.Бямбажавыг тус тус ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонголоо.

3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2888292 саналаар буюу 99.99%-ийн саналаар 2017 оны цэвэр ашгийн 50%-иар буюу нэгж хувьцаанд 21.33₮, нийт 74.2 сая.төг (далан дөрвөн сая хоёр зуун мянган) –ийг ногдол ашигт хуваарилахаар шийдвэрлэж, Гүйцэтгэх захиралд санхүүгийн бололцоотой үедээ 2018 оны 9 сард багтаан нийтэд зарлаж олгохыг даалгав.

4. Компанийн удирдлагын 2018 оны зардлын төсөвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 2888303 санал буюу 99.99%-ийн саналаар 52298.мян.төг (тавин хоёр сая хоёр зуун ерэн найман мянган)-өөр баталлаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ж.Нарантуяа

Хурлын Дарга

Д.Мөнхбат

Хурлын тооллогын комиссын дарга

Б.Цолмон